# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр　　　　Дугаар 387　　　　Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа орон нутаг дахь Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэрийн нийт 1,986,940.00 (нэг сая есөн зуун наян зургаан мянга есөн зуун дөчин) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Орон нутаг дахь Татварын хэлтсийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ируүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА　　　　З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА　　　　Д.НАРАНГЭРЭЛ

000729

D:\Huraldaanii material\2020 on\2020.07.06 11r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 07
дугаар сарын 06-ний өдрийн 387
дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа Орон нутаг дахь Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах үндсэн хөрөнгийн жагсаалт

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын дүн, Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Эзэмшигч байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Гараажийн барилга | 2008 | Ш | 1 | 268,100.00 | Баян-Өлгий аймгийн татварын хэлтэс |
| 3 | Тирлик захад байцаагчдын байр | 2011 | Ш | 1 | 348,790.00 | Баян-Өлгий аймгийн татварын хэлтэс |
| 4 | Улаан байшинт путка | 2008 | Ш | 1 | 44,690.00 | Баян-Өлгий аймгийн татварын хэлтэс |
| 5 | хайс | 2003 | Ш | 1 | 246,360.00 | Дорнод аймгийн татварын хэлтэс |
| 6 | Хуучин ТЕГ-ын гадаа хашаа | 2011 | Ш | 1 | 1,079,000.00 | Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс |
| | | | | **5 (тав)** | **1,986,940.00 (нэг сая есөн зуун наян зургаан мянга есөн зуун дөч)** | |